

“СТЕНД-АП” ТЕЛЕВИЗИЙН СУРВАЛЖЛАГЫН
ЧУХАЛ ХЭСЭГ БОЛОХ НЬ

Т.Өнөрсайхан*

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, магистр (МА), докторант

Түлхүүр үг: стэнд-ап, сэтгүүлч дэлгэцэнд, стэнд-апын синдром, үнэлэмж, сурвалжлагын бүтэц

Сэтгүүл зүйн мэдээлсэн бичлэгийн төрөл зүйлийн нэг сурвалжлагыг “нийтэд хамаатай нийгмийн чухал үйл явдал, үзэгдэлд зохиогч өөрөө оролцсоны үндсэн дээр үйл явдлын тухай нүдэнд үзэгдэж, сэтгэлд буутал дүрслэн мэдээлнэ”¹ гэж тодорхойлсон байна. Сэтгүүлч үйл явдлын гэрч болж оролцож байгаагийн хувьд харсан мэдээллээ “би” баатрын хувиар дамжуулах нь энэ төрлийн бичлэгийн нэг онцлог юм. Өөрөөр хэлбэл, сурвалжлагыг үнэн бодитой, сонирхолтой болгохын зэрэгцээ итгүүлэн үнэмшүүлэх чадварыг дээшлүүлдэг ач холбогдолтой билээ. Сурвалжлага цаг хугацаа, орон зайн хувьд хязгаарлагдмал, нэг л сэдвийг тойрч мэдээлдэг боловч жирийн амьдралд өрнөж буй үйл явдал, бодит байдлыг хачир чимэггүй, шуурхай харуулдагараа хамгийн түгээмэл бичлэгийн төрөл юм. “Сурвалжлагад зөвхөн өгүүлэхгүй харин үзүүлдэг”². Мэдээллийн нийгэм хөгжиж, шинэ хэрэгслүүд хүч түрэн орж

ирэхийн хирээр телевизийн сурвалжлага хэзээ, хаана, юу болов гэхээсээ яаж гэсэн асуултанд илүүтэй хариулт өгөх болсон. Төгс хариулт өгөхөд телевизийн сурвалжлагын бүрэлдэхүүн хэсэг бүр чухал үүрэг гүйцэтгэнэ.

Телевизийн сурвалжлагын бүтцийг үндсэн дөрвөн хэсэгт хувааж үзнэ.

- Эх бичвэр
- Дүрсэн өгүүлэмж
- Ярилцлага
- Бодит байдлын чимээ

Дээрх дөрвөн үндсэн хэсгээс гадна телевизийн сурвалжлагын онцлогийг харуулж, ач холбогдлыг тодорхойлсон хоёр бүрэлдэхүүн хэсэг байдаг. Лид болон стэнд-ап юм.

Стэнд-ап (англи хэлний stand-up босох, зогсох, орос хэлний репортёрская стойка (стендап) – сурвалжлагчийн зогсолт) болж буй үйл явдлын салшгүй хэсэг сэтгүүлчийн үзэгчдэд хандсан хүүрнэл яриа юм. Мэдээлэл, үйл явдлын халуун цэгээс нөхцөл байдлын талаар өөрийн мэдрэмжээ дамжуулах, онц чухал баримт гаргаж тавих, нэг сэдвээс нөгөөд шилжихэд сурвалжлагын аль нэг хэсгийн цөөн хоромд сэтгүүлч дэлгэцэнд ил гарч ярихыг хэлнэ. Оксфордын толь бичигт

“баримт, шаардлага, нотолгоо” ч гэж товчоор тайлбарлажээ.

Англи хэлний босох, зогсох гэсэн утгатай энэ үг мэргэжлийн хэллэгт сэтгүүлч камерын өмнө гарч, үйл явдлыг тайлбарлах гэж томъёологддог. Барууны сэтгүүл зүйн хэвшмэл хэллэг 1990-ээд оноос хойш манай телевизийн салбарт нэвтэрсэн. Өмнө нь Оросын сэтгүүл зүйгээр дамжуулан зарим нэг мэргэжлийн үг хэллэгийг ашиглаж, “в кадре” буюу сэтгүүлч дэлгэцэнд гарч тайлбарлах, тайлбар хийх, хөтлөлт хийх гэх зэргээр нэрлэж байв. Олон улсын сэтгүүл зүйн практикт телевизийн сурвалжлагын энэ бүрэлдэхүүн хэсгийн нэршлийг өөрийн онцлогт тохируулж орчуулахаас илүү мэргэжлийн тогтсон хэллэг болгож, дэлгэцийн өмнө зогсох буюу стенд-ап гэж хэрэглэж заншжээ.

Стэнд-ап-д сэтгүүлч сурвалжлагын аль нэг хэсэгт хэдхэн секунд үзэгдээд өнгөрч байгаа мэт боловч үр нөлөө, утга агуулгын олон ач холбогдолтой юм. Тухайлбал,

- Сэтгүүлч үзэгчдийн хооронд шууд харилцаа бий болно

- Сэтгүүлч олонд танигдана.

- Сурвалжлагын өгүүлэмжийн агуулгад гүнзгий орж илэрхийллэ

- Сурвалжлагыг сонирхолтой болгоно. Жишээ нь, шинэ бараа бүтээгдэхүүний талаар сурвалжилж байхдаа сэтгүүлч стенд-апаараа тухайн барааг шууд туршиж, үйлдвэрлэгчдийн хэлж байгаа зүйлийг үнэн бодитой эсэхийг шалгаж болно. Үзэгчид сэтгүүлчийг үйл явдлын гэрч гэж хардгаас оролцогч гэж тооцдоггүй байна. Тиймээс тухайн барааны чанарыг шалгахад хөнд-

лөнгийн шалгагчийн үүргийг сэтгүүлч гүйцэтгэж, үзэгчдийн итгэлийг дагуулна.

- Сэтгүүлч үйл явдлын гол дундаж байгааг батлан харуулна. Ингэснээр үзэгчдийн мэдээллийн үнэн бодит байдалд итгэх итгэлийг төрүүлнэ.

- Сурвалжлагын гол зангилаа чухал асуудалд үзэгчдийн анхаарлыг хандуулна. Дүрсэн өгүүлэмж, эх бичвэр хоёр зэрэгцэн явж байгаа тохиолдолд үзэгч харах мэдрэмжинд илүү анхаарч, зарим мэдээллийг анзааралгүй, сонсолгүй өнгөрөх тохиолдол байдаг.

- Үйл явдлын дүгнэлт, зангилаа тайлан болно.

- Нэг хэсгээс нөгөө хэсэг рүү үсрэлтгүй аажмаар шилжих боломж олгоно.

- Сурвалжлагын дүрсэн өгүүлэмж дутсан тохиолдолд нөхөөс болно.

- Хэцүү асуудлыг энгийн хялбараар тайлбарлах арга юм.

- Хүмүүст цаг хугацааны баримжаа өгнө. “Сурвалжлагад үйл явдал болсон газар нутаг, цаг хугацааг тодорхой заах нь тэргүүн зэргийн шаардлагатай байдаг. Бүр тодорхой бус үйл явдлын талаар өгүүлж байсан ч түүнийг цаг хугацаа, орон зайтай холбож өгсөн байх ёстой. Эс тэгвэл сурвалжлага үнэн бодит байх шинжээ алдаж, хийсвэр үйл явдлын тухай, уран зохиолын бүтээл шиг сэтгэгдэл төрүүлдэг болно”³. Өөрөөр хэлбэл, сурвалжлага яг энэ цаг мөчид болж байгааг баталдаг.

Сурвалжлага бүрт стенд-ап хийх шаардлагатай юу гэж залуу сэтгүүлчид асуух нь элбэг. Үүнээс стенд-апын үнэлэмжийн тухай ярих хэрэг гарч ирнэ.




График №1-д харуулсан таван асуултад бүрэн хариулж чадвал тухайн сурвалжлагад стенд-ап бүтцийн нэг элемент болсон гэсэн үнэлэмжийг бий болгосны баталгаа юм.

Өгүүлж буй сэдэвт хийх гэж байгаа стенд-ап сонирхолтой байж чадах уу? гэсэн асуулт хамгийн чухал нь байдаг. “Микрофон барьчихаад, хөшөө шиг хувиралгүй зогсож байгаа стенд-ап надад хэрэггүй. Жагсагчдын дунд ороод алх, чихэлдсэн хүмүүсийн дундуур зүтгэ, нурж унаж байгаа байшингийн дээвэр дээр суу, хөшөөний араас гарч ирээд ярь, хэн нэгэн алдартан ярьж байхад урд нь зогсоод тайлбар хий, эсвэл стенд-ап хийж байхдаа тэр алдартантай гар барьж мэндчил”. Эйн-Би-Си телевизийн Ерөнхий редактор Ройвен Франк сэтгүүлчиддээ ийм заавар өгдөг байна. Эйн-Би-Си телевизийн сурвалжлагчдын гарын авлагад стенд-апыг сонирхолтой, өвөрмөц шийдэлтэй, байнгын эрчимт хөдөлгөөнтэй хийнэ гэсэн зааварчилгаа бий. Ингэснээр уйтгартай, нэг хэвийн байдалтай дэлгэцийн өмнөх зогсолт биш үйл явдлын хэсэг болж, сонирхолтой өгүүлэмжийг давхар харуулах ач холбогдолтой юм.

Гэхдээ сонирхолтой байна гээд сэдвийн бүтцэд тохирохгүй үйлдэл хийхийн нэр биш ээ. Эх бичвэрийн зохион байгуулалтаа сайн бодолцох нь зүйтэй юм. Лидэнд өгүүлсэн утгыг эх бичвэрт давтаж, дахин стенд-апд хэлэх хэрэггүй гэсэн санааг илэрхийлж буй асуулт. Сурвалжлагыг мэдээлэл багатай харагдуулах, аль эсвэл ямар нэг санааг үзэгчдийн сэтгэлд хоногшуулах зорилготой нууц явуулга мэт хардлага төрүүлдэг. Ярилцлага өгсөн хүний хэлсэн үгийг ч стенд-апд давтан хэлэх нь зохимжгүй. Тэр хүний үгээр, ганцхан талаас асуудлыг үзүүлж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэх сөрөг талтай юм. Стенд-ап ямагт шинэ соргог, чухал мэдээлэл байна.

Үйл явдлын орон зайн мэдээллийг өгөх нь үзэгчдийн итгэл үнэмшлийг дагуулж, сурвалжлагын бодит байдлын илэрхийлэл болдог. Үйл явдлын сэдэв орчинтойгоо уялдах ёстой юм. Өглөөний жагсаалын тухай ярьж байж, оройн нар жаргах үед стенд-ап хийх нь үзэгчдийн итгэл үнэмшлийг бууруулж, цаг хугацааны хувьд хоцрогдсон сэтгэгдэл төрүүлдэг. Мөн УИХ-ын чуулганы хуралдааны тухай стенд-апыг Төрийн ордны аль нэг хананы өмнө зогсож байгаад өгүүлэх

нь сэдэв-орчны уялдаа алдагдсаны илрэл юм. Чуулганы хуралдаан ид өрнөж, “амьд” дүрсний өмнө стэнд-ап хийвэл хананы урд номхон зогсоноос илүү хүчтэй сэтгэгдлийг үзэгчдэд төрүүлж, мэдээллийн итгүүлж үнэмшүүлэх чанарыг нэмэгдүүлнэ.

Стенд-ап хийж байгаа үед сэтгүүлч үйл явдлыг үг хэл, байгаа байдлаараа төдийгүй, дүр төрхөөрөө илэрхийлж байж үзэгчдийн итгэлийг олдог. Спорт цамц өмсөж, саравчтай малгай тавьсан сэтгүүлч парламентын хуралдааны талаар яриад зогсох нь тийм ч зохимжтой хувилбар биш юм.

Дүрсэн өгүүлэмж, эх бичвэрээр өгүүлээгүй шинэ соргог мэдээлэл стэнд-апд багтаж байж телевизийн сурвалжлагын бүтцийн бие даасан элемент болно. Стенд-апд ганцхан сэтгүүлч анхаарлын төвд байдаг учраас эрчимт хөдөлгөөнтэй дүрс, дэлгэрэнгүй эх бичвэрээс илүү гарсан ашигтай, сонирхолтой мэдээлэл өгүүлж, үзүүлж байж үзэгчдийн анхаарлыг татах нь дамжиггүй юм.

Дээрх таван асуултад бүрэн хариулж чадвал телевизийн сурвалжлагын стэнд-апын гүйцэтгэх үүргийг биелүүлж чадсан байна гэж үзнэ.

“Стенд-апын синдром” гэсэн нэр томъёог стэнд-апын үнэлэмжийг тодорхойлсон таван үндсэн асуултад хариулж чадаагүй тохиолдолд ашигладаг. Үүнээс гадна:

- Зөвхөн “би” энд байна гэдгийг харуулж, онц шаардлагагүй байхад стэнд-ап хийх

- Нэг сурвалжлагад хэд хэдэн стэнд-ап хийж гарах

- Камерын өмнө ямар нэгэн тайлбар хийж болон хийхгүйгээр хэт удаан гарах

- Өгүүлэх баримт, бодит байдлыг сэтгэлийн хөдөлгөөнөөсөө салгаж

чадахаа байж, хувийн үзэл бодол дүгнэлтийг илэрхийлэх

- Төгсгөлгүй урт өгүүлбэрээрээ, шуу тайлбар хийх

Мэргэжлийн бус ажиллаж байгаагийн илэрхийлэл болсон дээрх алдаануудыг телевизийн салбарт “стэнд-ап синдром” буюу “сэтгүүлчийн дэлгэц хам шинж” гэж тодорхойлдог.

Стенд-ап телевизийн сурвалжлагын нэг бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд өөрийн хэм хэмжээтэй байна.

Телевизийн сурвалжлагын ярилцлага 15-20 секунд үргэлжлэхэд тухайн ярилцагчийнхаа хэлэх гэсэн санаа бүрэн гаргаж чаддаг. Стенд-ап хийж буй сэтгүүлч үйл явдлын гарч ирэх сурвалжлагын оролцогч болохын хувьд гол санаагаа илэрхийлэхэд мөн л ийм хугацаа хангалттай юм.

Стенд-ап хэдийгээр босох, зогсох гэсэн утгатай үг боловч телевизийн сэтгүүл зүйд эрч хүчтэй хөдөлгөөн бүжигнасан үйл явдлыг илэрхийлдэг. Аль болох номхон зогссон стэнд-апаас татгалзах нь зүйтэй. Хэвтэж, сууж, явж гүйж болно. Энэ бол сэтгүүлчийн чөлөөт сонголт, ур чадварын илэрхийлэл юм.

Зайлшгүй шаардлагаар номхон зогссон стэнд-ап хийхээр болсоо тохиолдолд камерын дунд дүрсээр сэтгүүлчийг авдаг. Үзэгчдэд дотроо сэтгэгдэл төрүүлж, харилцан ярилцагчийнхаа урд зогсож, нүд рүү нь чиглэх хараад ярьж буй мэт сэтгэгдэл төрүүлнэ.

Сэтгүүлчийн дүр төрх стэнд-апын хийхэд чухал нөлөөтэй. Хувцаслалт гадаад байдал, үг хэллэг болж буй үйл явдлын онцлогтой уялдана. Хэдий хурц нартай байсан ч хар шил зүүн малгайтай зогсох нь зохимжгүй юм. Үзэгчдийг үл хүндэтгэсэн сэтгэгдэл төрүүлдэг.

Зарим туршлагагүй залуу сэтгүүлчид стэнд-апын үгээ нэгбүрчлэн цээжилдэг. Цээжилсэн үг, сэтгэлээс гарч буй мэдрэмжийн илэрхийлэл болсон үгийг илэрхийлэх ялгаа маш их. Үзэгч цээжилсэн үгээ алдахгүйг хичээн хэлж буй сэтгүүлчийг шууд мэдэрдэг.

Камерын өмнө биеэ барихгүй, чөлөөтэй ярьж чаддаг байх нь сэтгүүлчийн ур чадварын илэрхийлэл юм.

Сэтгүүлч үгээ үзэгчдэд шууд хандаж хэлдэг. Стенд-апын үед камерын дуран үзэгчийг орлож харилцан ярилцагчийн дүр болдог. Харилцан ярилцагчийнхаа нүд рүү ширтэж ярих, ярианы төгсгөлд харцаа шууд буруулах зэрэг нь үзэгчдэд таагүй сэтгэгдэл төрүүлдэг.

Стенд-апын үед сэтгүүлчийн дууны өнгө чухал үүрэгтэй. Хуралдаан болж байгаа танхимд дуугаа намган шивнэх шахам стэнд-ап хийх нь тийм ч зохимжтой хувилбар биш юм.

Телевизийн сурвалжлагыг бүтцийн дарааллын хувьд ийм тийм байна гэж тогтсон хувилбар гаргах боломжгүй юм. Үйл явдлын өгүүлэмж, сэтгүүлчийн ур чадвар, туршлага, бичлэгийн онцлогоос шууд шалтгаалдаг. Стенд-апыг сурвалжлагын аль хэсэгт оруулах нь сэтгүүлчийн тухайн үеийн бичлэгийн онцлог, нөхцөл байдлаас хамаарна. Ерөнхийд нь хэлбэрийн хувьд гурав хуваадаг.

- Сурвалжлагын эхэнд буюу үйл явдлын тухай анхны мэдээллийг өгөх хэлбэр.

- Сурвалжлагын дунд хэсгийн стэнд-ап буюу “гүүр” хэлбэр. Нэлээн түгээмэл хувилбар юм. Нэг хэсгээс нөгөө хэсэг рүү, аль эсвэл нэг сэдвээс нөгөө сэдэв рүү шилжихэд холбоос болно. Мөн дүрсэн өгүүлэмж дутсан тохиолдолд сэтгүүлч мэдээллийн үнэн бодит байдлын баталгаа болж, үзэгчдэд итгэл үнэмшил төрүүлэх

зорилгоор энэ хэсэгт стэнд-ап хийдэг. Сурвалжлагыг шууд эфирт дамжуулж байгаа тохиолдолд “гүүр” стэнд-апыг илүү ашигладаг.

- Сурвалжлагын үр дүн, тайлангийн зангилаа болсон төгсгөлийн стэнд-ап гэж гурав хувааж үзнэ.

Дээрх гурван хэлбэрээс гадна барууны зарим телевизийн сурвалжлагад мэдээлэх стэнд-ап хувилбарыг ашигладаг. Сурвалжлагын газар очсон боловч өгүүлж үйл явдлын дүрсийг авч амжаагүй, байхгүй тохиолдолд сэтгүүлч орон зайн мэдээллийг илэрхийлж, стэнд-ап хийдэг. “Халуун цэгүүд” дайн байлдаан, байгалийн гамшигт үзэгдлийг сурвалжилж байгаа үед сэтгүүлч дүрс авах боломжгүй байдаг. Ийм нөхцөлд мэдээлэх стэнд-апыг ашигладаг. Америк болон барууны телевизүүдэд илүү дэлгэрсэн энэ хэлбэрийг стэнд-ап гэхээсээ үйл явдлын тайлбар гэж үзвэл зохимжтой юм.

Монголын телевизийн сэтгүүл зүйн практикт эхлэл болон төгсгөлийн стэнд-апыг илүүтэй ашигладаг. Гэхдээ сурвалжлагыг бүрдүүлэгч хэсэг гэхээсээ сэтгүүлчийн үзэл бодлын талбар, аль эсвэл өөрийгөө үзэгчдэд харуулж, дэлгэцээр гарах арга болгон хэрэглэж байгаа дутагдалтай тал нилээд ажиглагдаж байна. Энэ нь стэнд-апын онцлог, хэм хэмжээ, ач холбогдлын талаар мэдлэг дутмаг байгаагийн илрэл юм.

Олон улсын сэтгүүл зүйн практик мэргэжлийн сэтгүүлчдийн бүтээлийг тодруулахдаа стэнд-апыг тусгай төрөл болгож шалгаруулалт явуулдаг. Жишээ нь, бүх Оросын “Энхтайван, итгэлцэл, эв нэгдэл” теле наадмын телевизийн сурвалжлага гэсэн ангилалд “Шилдэг стэнд-ап” шагналыг тусгайлан олгодог уламжлалтай. Ингэхдээ агуулга, ур

чадвар, хийц, хэлбэрийн онцлогийг харгалзан шилдгийг тодруулдаг байна. Энэ нь стэнд-ап телевизийн сурвалжлагын чухал бүрэлдэхүүн, онцло, үзэсгэдгийг олон улсад хүлээн зөвшөөрч, баталж байгаагийн нэг илэрхийлэл юм.

Ишлэл

¹ Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйл. УБ., 93 дахь тал.

² Зулькафиль М. 2012. Сэтгүүлчийн ур чадвар. 3-р боть. УБ., 194 дэх тал.

³ Дурд. зох., 192 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М. 2012. Сэтгүүлчийн ур чадвар. 3-р боть. УБ.

2. Норовсүрэн Л, Ариунзаяа Н. 2009. Телевизийн сэтгүүл зүй. УБ.

3. Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйл. УБ

4. Корконосенко С. Г. 2000. Основы творческой деятельности журналиста. СПб.

5. Прохоров Е. П. 1993. Введение в теорию журналистики. М.

6. Цвик В. Л., Назарова Я. В. 2002. Телевизионные новости России. М.

7. Besse B., Desormeaux D. 2007. Television news reporting from design to delivery. France.

8. Eastman S. T, Ferguson D. A. 2012. Media programming: strategies and practices. Cengage learning.

9. 2011. Asiavision coordinators meeting. Langkawi.

10. 2009. The responsibilities of a chief editor. Training session. Bangkok.

Summary

The article discusses the analysis of reporter stand-ups. The purpose of a stand-up is to show the audience who the reporter actually is, but there is much more. The stand-up can take the viewer from one place or concept to another place or concept. Another purpose for a stand-up can be to tell the part of a story that doesn't have any good pictures to go with it. In Mongolia reporter stand-ups issues are not commonly reviewed and studied in the recent years, therefore further research studies required to be done in this field.